



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/591

Арвайхээр

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн  
бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд  
зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "б", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 21 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх зорилгоор Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаагаар сунгасугай.

2.Арвайхээр сумын баруун хяналтын цэг болон Дайргын гол, Тарнын пост дахь хяналтын цэгүүдийн үйл ажиллагааг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн шинээр нэмж байгуулан ажиллуулсугай.

3.Халдвартай бүсээс ирсэн иргэдийг гэрийн хязгаарлалтад 14 хоног байх хугацаанд халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж, хяналт тавьж, хамтран ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), Эрүүл мэндийн газар (Д.Шиваанүрдэв), сум, багийн Засаг дарга нар, СӨХ-ийн дарга, гудамж, хэсгийн ахлагч, Улаан загалмайн хорооны сайн дурын идэвхтэн гишүүдэд тус тус үүрэг болгосугай.

4.Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа худалдаа, үйлчилгээний байгууллагуудыг хэвийн ажиллуулж, хүнсний худалдааны газруудын ажиллах цагийн хуваарийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн 09:00-20:00 цаг, төв бараан захын худалдааг 10:00-18:00, бусад үйлдвэр, үйлчилгээний байгууллагуудыг 10:00-20:00 цаг хүртэл тус тус ажиллуулсугай.

5.Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргийг бууруулсантай холбогдуулан хүнсний худалдаа, үйлчилгээний цэгүүдэд 18 хувиас дооших спиртийн агууламжтай согтууруулах ундааг худалдаалах, түүгээр үйлчлэхийг зөвшөөрсүгэй.

6.Улсын чанартай авто замын дагуух үйл ажиллагаа явуулж буй үйлчилгээний газруудыг хэвийн горимд шилжүүлж, дээрх цагийн хуваарийн дагуу халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөн ажиллахыг зөвшөөрсүгэй.

011101340

D:My Doc. Zahiramj. Zasag darga

2.

7.Худалдаа, үйлчилгээний, төвүүдийн гадна, дотор талын ариутгал, халдваргүйтгэлийг тогтмол хийлгэж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), Зооноз өвчин судлалын төв (Б.Сүхбаатар), сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

8.Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтийн тээврээр зорчих хөдөлгөөнийг нээж, сум хооронд, сум доторх нийтийн тээвэр эрхлэгчдэд чиглэл хүргүүлж, халдвар хамгаалал, ариутгалыг тухай бүр хийлгэж, аюулгүй байдлыг мөрдөж ажиллах, үйл ажиллагааг бүртгэлжүүлж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Авто тээврийн төв (З.Балданням), сумын Засаг дарга нарт даалгасугай.

9.Хужирт суманд үйл ажиллагаа явуулж буй рашаан сувилалуудыг ажиллуулах, үйлчлүүлж байгаа иргэдийг бүртгэлжүүлж зөвхөн аймгийн харьяалалтай иргэдэд үйлчлэх нөхцөл шаардлагын хүрээнд хамтран ажиллах, хяналт тавих арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв), Хужирт сумын Засаг дарга (Т.Баярмөнх) нарт үүрэг болгосугай.

10.Олон нийтийг хамарсан урлаг, спортын нэгдсэн арга хэмжээ, бүх төрлийн сургалтын үйл ажиллагаа, жагсаал цуглаан, цахим тоглоомын газар, интернет кафе, урлаг, спортын заал, усан бассейн, фитнес клуб, диско баар, караокены үйл ажиллагааг 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдөр хүртэл түр хориглосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ